

11. Гадаад харилцаанд оролцогч манай байгууллагуудын ажлын уялдаа холбоо, зохицуулалт, харилцан мэдээлэл солилцох явдлыг эрс сайжруулах, ялангуяа ГХЯ-ны гадаад бодлогын нэгдлийг хангах үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэх тодорхой арга хэмжээ авах хэрэгтэй гэж үзнэ.

12. Гадаад бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хувь заяа эцсийн эцэст боловсон хүчний бэлтгэл, боловсрол мэдлэг, хариуцлагаас хамаарна. Үүнтэй уялдан үндэсний дипломат албыг бэхжүүлэх, ажиллагсдын ахуй нөхцөлийг сайжруулах, боловсон хүчин бэлтгэх тогтолцоог бий болгох, Дипломат албаны хуулийг даруй боловсруулж гаргах зэрэг ажлыг хийх зорилт тулгарч байна.

Гадаад бодлогын шинэ зорилтуудыг хэрэгжүүлэхэд объектив болон субъектив шинжтэй бэрхшээлүүд тохиолдох нь ойлгомжтой. Гаднаас шалтгаалах ч зүйл бий, биднээс шалтгаалах зүйл ч, урьдаас өвлөгдсөн бэрхшээлтэй асуудлууд ч байна, шинээр гарч ирж байгаа цаг үеийн дуудлага ч байна. Санхүүгийн хомсдол ч тодорхой хэмжээний сааруулагч хүчин зүйл болж байна.

Гадаад бодлого Монгол Улсын оршин тогтнох болон хөгжин дэвшихийн нэгэн язгуур хүчин зүйл байсан, цаашид ч байх болно. Энэ утгаараа түүнийг шинжлэх ухааны үндэстэй боловсруулж оновчтой явуулах нөхцөлийг бүх талаар бүрдүүлэх явдал төр, засгийн онцгой анхаарлын объект цаашид ч байна гэдэгт бид эргэлзэхгүй байна.

**АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД  
НӨХЦӨЛ, МОНГОЛ УЛСЫН БОДЛОГО  
\*Ж. Энхсайхан**

“Хүйтэн дайн дуусч, хоёр туйлт ертөнц үгүй болсон билээ. Зүүн Европ, Евразийн ууган нутгийн улс түмэн улс төрийнхөө тусгаар тогтнолыг сэргээх буюу зарлаж, улс орноо ардчилал, зах зээлийн эдийн засгийн замаар хөгжүүлэх бодлого явуулж байна. Хэдийгээр дэлхий дахины, түүний дотор цөмийн дайны аюул багасч, улс

гүрнүүдийн эрх тэгш, чөлөөтэй хамтарч ажиллах боломж нэмэгдсээр байгаа боловч хоёр туйлт дэлхий ертөнц үгүй болсны дүнд бүс нутгийн хэмжээнд нөлөөгөө тогтоож авах буюу хадгалж үлдэх гэсэн эрмэлзэл сонирхол хүчтэй улс орнуудын дунд ихсэж байгаагийн дээр үндсэрхэг үзэл, үндэстэн ястан, шашин хоорондын зөрөлдөөн нэлээд гарч байна. Тийм ч учраас цөмийн болон бусад зэвсэг дэлгэрэн тархах аюул багасахгүй байна.

Олон улсын байдал ийм алаг цоог шинжтэй байгаа боловч үндэснийхээ аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлоо хангахад манай улсын хувьд бүхэлдээ таатай нөхцөл бүрдэж байгаа нь дараахь байдлаас тодорхой байна.

1. Манай улс гадаад харилцаандаа бодит байдалд тулгуурласан, үндэснийхээ ашиг сонирхлыг дээдэлсэн, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого явуулах боллоо.

2. Аюулгүй байдлаа ихэвчлэн улс төрийн аргаар хангаж олон улсын баталгаатай болгох бодлого баримтлах боллоо. Манай улс хөрш хоёр оронтойгоо харилцах асуудалдаа тэргүүн зэргийн ач холбогдол өгч байгаа явдал улс төрийн бодит байдалд тулгуурласан бодлогын илрэл юм.

3. Нэг талаас олон улсын харилцаанд гарч буй өөрчлөлтүүд хөрш хоёр оронтой харилцах харилцаанд болон ер нь нөгөө талаас гадаад бодлогод гарч байгаа нааштай өөрчлөлтүүдийн дүнд манай аюулгүй байдлын гадаад орчин өөрчлөгдлөө. Монгол Улсын аюулгүй байдал гагцхүү хөрш хоёр орноос, тэдний харилцаанаас хамаардаг байсан байдал өөрчлөгдөж, аюулгүй байдал өөрийн бодлогоос, цаашилбал олон улсын ерөнхий байдлаас нэлээд хамаарах болж байна.

4. Монгол улс хөрш оронтойгоо тэнцвэртэй харилцах зарчим баримтлах боллоо. Энэ нь манай өөрийн ашиг сонирхолд нийцсэн уян хатан бодлого юм. Учир нь гэвэл тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэх бодлогыг хэлж байгаа юм. Эдгээр оронтой харилцахдаа хөрш орнуудаас Монгол Улсын ашиг сонирхол, нэн ялангуяа язгуур ашиг сонирхлын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзан тусгаж байх болж байна. Монгол Улсын язгуур ашиг сонирхлыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд үл оролцож төвийг сахих бодлого баримтлах боллоо.

Монгол Улс хөрш хоёр оронтойгоо хоёулантай нь найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулсан нь эдгээр улсаас манайтай харилцах зарчмыг нь тодорхойлж улмаар манай гадаад байдлыг эрх

зүйн хувьд бэхжүүлэв. Манай хоёр хөрш гадаадын цэрэг, цөмийн болон үйл олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхгүй гэсэн манай бодлогыг хүндэтгэх үүрэг авсан билээ.

Харилцаагаа ихэвчлэн хоёр хөрш орноор хязгаарлах бодлого баримтлах нь гадаад бодлогын үйл ажиллагааг чөдөрлөхөөс гадна тэдний хараа хяналтад байлгах аюултай. Тиймээс ч Монгол Улс нээлттэй, бүх улс оронтой адил тэгш харилцах замаар олон тулгууртай гадаад бодлого явуулж байна. Манай улсын энэхүү бодлогыг олон улс орон, түүний дотор нөлөө бүхий улс орнууд дэмжиж байна. Нээлттэй гадаад бодлого явуулж, гадаадын хөрөнгийг Монгол Улсад оруулах нь манай эдийн засгийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхээс гадна бусад улсын эдийн засгийн сонирхлыг, түүнийг дагасан улс төрийн сонирхлыг буй болгох учиртай.

Ардчиллыг цаашид хөгжүүлэн баталгаажуулах нь монголчууд бидний сонгож авсан нийгэм-төрийн байгууллыг бэхжүүлэхэд дөхөмтэй байхаас гадна ардчилал хөгжсөн, зах зээлийн эдийн засагтай нөлөө бүхий улс орнуудын улс төрийн сонирхлыг татаж байна.

Монгол Улс эвсэлд үл нэгдэх бодлого явуулж, дэлхийн том жижиг 120 орчим улс орныг нэгтгэсэн эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний бүрэлдэхүүнд орсон явдал тэдэнтэй ашиг сонирхол нийлж буй асуудлаар том улс гүрэнтэй харилцахад манай улсын улс төрийн жинг. нэмж өгч, улс төрийн баталгааг бэхжүүлж байна. Хэдий тийм боловч олон улсын харилцааны бодит байдлыг харгалзан Монгол Улс нь өөрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд цэргийн шууд заналхийлэл учрах буюу тийм бодитой аюул буй болох нөхцөлд язгуур ашиг сонирхлоо удирдлага болгон бусад улс орон, бүлэг улстай түр эвсэх, зарим улс орон болон олон улсын байгууллагаас тусламж авах явдлыг үгүйсгэх ёсгүй бөгөөд түүнийгээ бусдаас нуух хэрэггүй мэт санагдана.

Зүүн хойд болон Төв Азийн бүс нутгуудын аюулгүй байдлыг хангах механизм буй болгох бодлого өнөөдөр газар авч байна. Монгол Улс уг механизмыг байгуулах яриа хэлэлцээнд бүр эхнээс нь идэвхтэй оролцож, өөрийн аюулгүй байдлыг бүс нутгийн байдалтай шууд холбож, Монгол Улсад аюул занал учрах нөхцөлд тэр нь бүс нутгийн хүчний тэнцвэрийг алдагдуулах, өөрөөр хэлбэл олон улсын энх тайван, аюулгүй байдалд шууд занал учруулах тийм механизм буй болгох талаар уйгагүй ажиллах хэрэгтэй юм.

Улс орноо цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарласан манай бодлого бол урьд өмнөх гашуун туршлагаас сургамж авсны, аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах бодлогын илрэл мөн.

УИХ-аар хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал нь монголчууд өөрийн язгуур ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдал гэж чухам юуг хэлэх, тэдгээрийг хэрхэн хангах зэрэг асуудлаар нэгдсэн нэг ойлголттой болоход дөхөмтэй болж, улмаар аюулгүй байдлаа хангах таатай нөхцлийг бүрдүүлж байна.

Уг үзэл баримтлалаар Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үндэс нь аливаа аюулыг “болзошгүй” үед нь тодруулан тогтоож арилгах, өөрөөр хэлбэл урьдчилан сэргийлэх явдал юм. Үзэл баримтлал нь аюулгүй байдлыг явцуу, зөвхөн сонгомол, цэрэг-улс төрийн утгаар нь бус, харин өргөн утгаар нь тодорхойлж, эдийн засаг, монгол соёл иргэншил, иргэний эрх, эрх чөлөө, хүн ам, удмын сан, шинжлэх ухаан-техник, мэдээлэл, экологи зэрэг манай нийгмийн амьдралын үндсэн салбаруудыг хамарч, XXI зуун руу харж байгаагаараа онцлог юм.

Улс орныхоо аюулгүй байдлыг хангахад бүрдэж буй аятай таатай нөхцлийг цаг алдалгүй тун зөв ашиглаж бататгах явдал өнөөгийн гадаад бодлогын нэг чухал зорилт байх ёстой.

Олон улсын харилцааны өрнөлт хөгжил зогсонги байдаггүй билээ. Улс орнуудын дотоод бодит байдал, хэрэгцээ, шаардлага, гадаад бодлогын зорилт зэргээс олон улсын байдал, хүчний харьцаа хамаардаг билээ.

Бид өнөөдрийнхөө байдалд зохицсон гадаад бодлого явуулбал учир дутагдалтай байх болно. Санаа амарлингуй байж болохгүй, аюулгүй байдлаа ямагт бодож бэхжүүлж байх шаардлагатайг олон улсын харилцаанд гарч байгаа зарим үйл явдал гэрчилж байна. Хөрш хоёр орны дотоод байдал, гадаад бодлогод гарах өөрчлөлтүүдийн өнгө аясыг сайтар судалж байх замаар хэтийн бодлогынхоо үндсийг өнөөдөр тавьж байх ёстой. Тухайлбал хоёр хөрш орны дотоод байдал хэрхэн өөрчлөгдөж, тэр нь ямар үр дагавартай байж болох, эдийн засгийн уналт буюу түргэн хөгжил тухайн улс орны гадаад бодлогод, түүний дотор манай улсад хандах хандлага, харилцаанд хэрхэн нөлөөлж болох зэргийг эртнээс сайтар судалж бодлого боловсруулан хэрэгжүүлж байх явдал чухал байна.

Тийм ч учраас Монгол Улсын гадаад бодлого өөрийн ашиг сонирхлыг зөв тусгасн олон улсын харилцааны өнөөгийн байдал, ирээдүйн өрнөлтийг урьдчилан харж чадсан, идэвхи санаачилгатай бодлого явуулах хэрэгтэй юм. Тухайлбал Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс болгох тухай саналыг аюулгүй байдлаа хангах нэгэн чухал хүчин зүйл болгох боломж байна. Манай энэхүү санал цөмийн Зэвсгийг үл дэлгэрүүлэх замаар цөмийн дайны буюу мөргөлдөөний аюулыг барьж байх гэсэн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг

бэхжүүлэх нийтлэг ашиг сонирхолд нийцэж байгаа юм. Ийм ч учраас НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн бүгд манай саналыг дэмжсэн бөгөөд энэ нь зөвхөн манай улсын хувьд төдийгүй ер нь олон улсын харилцааны практикт шинэлэг зүйл болов. Манай жишээгээр бусад улс гүрэн, нэн ялангуяа Төв Ази, Солонгосын хойг, Зүүн өмнөд Азийн орнууд цөмийн зэвсэггүй бүс байгуулбал энэ нь олон улсын аюулгүй байдлыг, түүний дотор манай ч аюулгүй байдлыг бэхжүүлэх юм.

Цөмийн зэвсэггүй бүс болгох нь тэр тухайга зарлаж бусдаар дэмжүүлснээр хязгаарлагдвал учир дутагдалтай болж, ЗХУ-ын олон санал, санаачилгуудын адил тодорхой үр дүнгүй болох юм. Иймд цөмийн зэвсэггүй статусаа олон улсын эрхээр, нэн ялангуяа НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийн үүрэг амлалтаар баталгаажуулж, статусыг аливаа улс зөрчих нь Монгол Улсын төдийгүй олон улсын аюулгүй байдалд хор хохирол давхар учруулах тийм механизм буй болгох шаардлагатай байна. Үүнийг Монгол Улс л өөрийн санаачилга, хүчин чармайлтаар буй болгож чадна. Саналаа цөмийн зэвсэгтэй улс орнуудаар дэмжүүлсний дараа бид одоо юу хийх вэ гэсэн асуулт гарч байна. Юуны өмнө саналаа хууль эрхийн үндэстэй болгох үүднээс Монгол Улсыг цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан хууль гаргаж, түүнд Монгол Улс цөмийн зэвсэг буюу түүний хэсгийг нутагтаа оруулж байрлуулах, туршихыг зөвшөөрөхгүй, гадаадын цэргийн онгоц, зэвсэг техникийг Монголд оруулах, дамжуулан өнгөрүүлэх нөхцөлд тухайн үед нь холбогдох улсаас нь мэдээлэл авч баталгаа гаргуулж байх, шаардлагатай үед шалгаж байх үүргийг Монгол Улсын Засгийн газарт олгох, статусыг зөрчсөн этгээд, байгууллагад Монгол Улсын хэмжээнд хүлээлгэх хариуцлагыг тогтоох, хариуцлагыг бусад улс, гадаадын байгууллагатай тооцох. нөхцөлд шаардлага гарвал НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл буюу Олон улсын шүүхийн туслалцаа дэмжлэгийг авах, статусын биелэлтэд үндэсний болон олон улсын хяналт тавих журам тогтоож, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд жил бүр мэдээлж байх зэрэг заалтуудыг тусгаж болох юм.

Олон улсын энх тайван, аюулгүй байдлын ашиг сонирхолд нийцсэн ийм хууль гарсан байхад НҮБ манай статусыг хүндэтгэж, бололцооныхоо хэрээр улс төр, техник-эдийн засгийн тусламж дэмжлэг үзүүлэх нь тодорхой юм.

АНУ манай саналыг дэмжихдээ хэрэв Монгол Улс хэзээ нэгэн цагт ямарваа аюул заналтай тулгарч, асуудлыг НҮБ-ын Аюулгүй Зөвлөлд тавибал АНУ Зөвлөлийн бусад гишүүний хамт зохих арга хэмжээний асуудлыг авч хэлэлцэх болно гэж мэдэгдсэн билээ. Хэрэв манай улс хууль гаргаж статусаа бататгаж чадвал манай энэхүү статус Монгол Улсын хувьд аюулгүй байдлын чухал баталгаа болох юм. Энэ мэтчилэн хэрэв манай улс идэвхи санаачилгатай гадаад бодлого

явуулбал экологийнхоо аюулгүй байдлыг ч олон улсын экологийн аюулгүй байдлын салшгүй хэсэг болгох боломж байна.

**АЗИ-НОМХОН ДАЛАЙН ХАМТЫН  
НИЙГЭМЛЭГИЙН ДҮР ТӨЛӨВ, ТҮҮНД  
МОНГОЛЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙН АСУУДАЛД  
Ц. Батбаяр\***

АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон нэг жилийн өмнө Японд айлчлах үеэр Васэда Их сургууль дээр 7 дугаар сарын 7-нд хэлсэн үгэндээ “Номхон далайн шинэ хамтын нийгэмлэгийн” үзэл санааг анх дэвшүүлсэн билээ. Энэ үзэл санаа нь цагийн аясыг дагасан хоосон чамирхал бус, харин хүйтэн дайны дараахь Ази-Номхон далайн бүс нутгийн шинээр бүрэлдэн буй бодит байдлыг илэрхийлсэн санаачилга гэж хэлж болно.

Хүйтэн дайн шувтарснаар тус бүс нутгийн орнуудын хоорондын цэрэг-стратегийн болон газар нутгийн зөрчил маргаан үргэлжилсэн хэвээр байгаа боловч тэдний хоорондын худалдаа-эдийн засгийн харилцан хамаарал улам бүр нэмэгдэх төлөвтэй. Юуны өмнө, Азийн, ялангуяа Зүүн Азийн орнуудын түргэн хурдацтай эдийн засгийн хөгжил дэлхий нийтийн анхаарлыг татах боллоо. “Зүүн Азийн эдийн засгийн гайхамшиг” /The East Asian Economic Miracle/ төсөл ч үүнийг тод нотолж байна. Азийн орнууд нь 2 тэрбум хүн ам буюу, өөрөөр хэлбэл 2 тэрбум хэрэглэгчтэй асар том зах зээл болж хувирч байна. АНУ-ын Сангийн сайд Бентсений хэлснээр дундаж орлоготой америкчуудтай тэнцэх худалдан авах чадвартай өрх айлын тоо Азид зургаахан жилийн дараа 75 саяас давах ажээ.

Эх газрын Хятад, Тайвань, Гонконгийг хамарсан нэг ёсны “Их Хятадын эдийн засгийн бүс” бүрэлдэж байна. Түүн дотор сүүлийн арваад жилд тэрбум гаруй хүн амтай Хятадын эдийн засгийн Хөгжлийн хурдац жилд 10%-иас давж байна. Өнөөдөр дэлхий нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүний /Gross Domestic Product/-ын 23 орчим хувийг АНУ, 16%-ийг Япон эзэлж байгаа боловч ирэх 21 дүгээр зууны эхний хагаст Хятадын эдийн засаг үнэмлэхүй хэмжээгээр дэлхийн хамгийн том нь болох нь бараг эргэлзээгүй зүйл боллоо.

Нөгөө талаас, Ази-Номхон далайн бүс нутагт ардчиллын салхи үлээх төдий бус шуурга шуурч эхэллээ. Улс төрийн диктатур, тэр ч байтугай цэргийн дэглэм ноёрхсон оронд эдийн засгийн өсөлт

\* Ц. Батбаяр - Дэд доктор, ДДОУСХ-гийн захирал